

**ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАЙГУУЛЛАГА (ИСАО)-ЫН АЗИ, НОМХОН
ДАЛАЙН БҮСИЙН ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР (CASP-AP)-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 19-Р
ХУРАЛ БОЛОН АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗОХИЦУУЛАЛТЫН 12-Р ФОРУМ (RASCF-APAC/12)-Д ОРОЛЦСОН ТАЙЛАН**

2024 оны 07 дугаар сарын 29-ний өдөр

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Удирдах Зөвлөлийн 19 дүгээр хурал (CASP-AP SCM/19) болон Ази, номхон далайн бүсийн Аюулгүй байдлын зохицуулалтын 12 дугаар форум нь (RASCF-APAC/12) Филиппин Улсын Манила хотод 2024 оны 07 дугаар сарын 23-аас 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд ИНЕГ-ын даргын 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/358 дугаар тушаалын дагуу тус хуралд Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ч.Одгэрэл, Аюулгүй ажиллагааны дотоод хяналт, дүрмийн боловсруулалтын албаны дарга С.Ерханат, Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны Аэродром, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга бөгөөд нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын ахлах байцаагч Г.Мөнхболд нарын бүрэлдэхүүнтэй оролцов.

CASP-AP SCM/19 хурлын тухай

Ази, Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Удирдах Зөвлөлийн 19 дүгээр хурал нь 2024 оны 07 дугаар сарын 23-аас 24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд нийт 17 гишүүн орны 40 төлөөлөгчид, олон улсын 6 байгууллагын 8 төлөөлөгч, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 7 төлөөлөгч нийт 55 төлөөлөгчтэйгөөр хуралдан, шийдвэрүүдийг гаргасан.

Иргэний нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Удирдах зөвлөлийн 18 дугаар хурлаас 2023-2024 онуудад Монгол Улс хөтөлбөрийн Удирдах зөвлөлийг даргалахаар шийдвэрлэсэн ба энэхүү үүрэгт ажилд Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ч.Одгэрэл сонгогдон ажилласан. Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ч.Одгэрэл Удирдах зөвлөлийг тэргүүлэн ажиллах хугацаанд хэрэгжүүлсэн ажлыг 19 дүгээр хурал дээр товч танилцуулж Удирдах зөвлөлийн даргын үүргийг Филиппин Улсын Тээврийн аюулгүй байдлын газрын дарга Jose A Briones Junior-д хүлээлгэн өгсөн.

Ази, Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Удирдах Зөвлөлийн 19 дүгээр хурлаас дараах шийдвэрүүдийг баталсан.

1. Ази, Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Удирдах Зөвлөлийн 18 дугаар хурлаас гарсан шийдвэрүүдээс 8 шийдвэр бүрэн хэрэгжиж дууссан, 11 шийдвэр үргэлжлэн хэрэгжиж байгааг тогтов. Өмнөх хурлын шийдвэрээс 2024-2025 онд үргэлжлэн хийгдэх ажилд:
 - а. CASP-AP гишүүд бүс нутгийн хэмжээнд эрсдэлийн нөхцөл байдлын мэдэгдлийн статусыг анхаарах;

- б. CASP-AP гишүүд Эрсдэлийн удирдлагыг үргэлжлүүлэн онцгой анхаарч ажиллахыг хүлээн зөвшөөрөв;
- в. CASP-AP гишүүд Удирдах зөвлөлийн 18 дугаар хурлаас дэвшүүлсэн нэмэлт асуудлуудыг хүлээн зөвшөөрөв;
- г. Бүх CASP-AP гишүүд CASP-AP Secure Portal ашиглан баримт бичиг солилцох шаардлагатайг онцлон сануулав;
- д. CBT зураг авах;
- е. Далд тест хийх гарын авлага боловсруулах;
- ё. Кибер аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх семинар зохион байгуулах;
- ж. Кибер аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх баримт бичиг боловсруулах;
- з. Нууцлалтай тайлагнах системийн удирдамжийг боловсруулах;
- и. Хамгаалагдсан бүсийн гадна нисэхийн аюулгүй байдал сэдвээр семинарын материал боловсруулах;
- й. Карго аюулгүй байдлыг хангах олон улсын хамгийн сайн туршлагыг хуваалцах семинар зохион байгуулах гэсэн ажлууд багтав.

2. CASP-AP хөтөлбөрийн хүрээнд 2024-2025 онд хэрэгжих 7 төрлийн нийт 71 арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр батлав. Батлагдсан 71 арга хэмжээнүүдээс Монголын талаас тавьсан хүсэлтийн дагуу 2025 онд "Албадлагын арга хэмжээ" семинарыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын тухайн чиглэлээр мэргэшсэн зөвлөх болон хөтөлбөрийн зохицуулагч, сургалтын мэргэжилтний хамтаар Монгол Улсад зохион байгуулах, мөн CASP-AP хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдаж гишүүн орнуудад үнэ төлбөргүй санал болгож байгаа CBT /Computer Based Training/ болон ORR /Oversight, Reporting and Resolution/ программ хангамжийг суурилуулах ба ашиглах семинарыг зохион байгуулахаар батлагдсан. CBT болон ORR программ хангамжийг авахаас өмнө тухайн улс нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагатай программ хангамжийн лиценз ашиглах гэрээг байгуулсан байх шаардлагатай тухай танилцуулагдсан.
3. CASP-AP хөтөлбөрийн 2024-2025 оны төсвийг 333,395 ам. доллар байхаар батлав. Батлагдсан төсвийн 10,185 ам. долларыг Монгол Улсад 2025 онд зохион байгуулагдах "Албадлагын арга хэмжээ" семинар хөтлөн явуулах Олон улсын иргэний нисэхийн байгууллагын тухайн чиглэлээр мэргэшсэн зөвлөхийг хөлслөх зардалд зарцуулахаар батлагдсан болно.

Ази, Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Удирдах Зөвлөлийн 19 дүгээр хуралд "Хориотой аюултай бараа"-д хяналт тавьж байгаа Сингапур улсын туршлага, "USAP-CMA ажлын хэсгийг Ази, Номхон далайн бүсийн хүрээнд байгуулах" Филиппин улсын санаачилга, "Нисэхийн аюулгүй байдлын APEX үнэлгээний тухай" Олон улсын нисэх буудлуудын холбоо, "ICAO ISD-SEC хөтөлбөр" болон "ICAO Capacity Development and Implementation Activities" Олон улсын иргэний нисэхийн байгууллага, "Филиппин улс дахь нисэх буудлуудын хувьчлал ба төлөвлөлтийн зураг төслийн үед нисэх аюулгүй байдлыг хангуулах зааврын хэрэгцээ" асуудлаар Филиппин, "Мэдэгдээгүй аюултай барааг нисэх буудлын үзлэгийн шалгагч нар илрүүлэх" асуудал Тайланд, "GASeP зорилтууд, Ази, Номхон далайн бүсийн USAP-CMA/Cycle II аудитын үр дүн" зэргийг багтаасан Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази, номхон далайн бүсийн төвөөс тус тус танилцуулга хийж, хэлэлцүүлгийг өрнүүлсэн болно.

RASCF-APAC/12 форумын тухайд

Ази, номхон далайн бүсийн Аюулгүй байдлын зохицуулалтын 12 дугаар форум нь 2024 оны 07 дугаар сарын 25-аас 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд дараах ерөнхий агуулгын хүрээнд нийт хэлэлцүүлэх хуудас 5, мэдээлэх хуудас 2, танилцуулах материал 25-ыг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн болно.

а. AVSEC/FAL-ын нэмэлт өөрчлөлтүүд: ICAO USAP-CMA, нисэхийн аюулгүй байдалд хамаарах шинээр гарч ирж буй заналхийлэл, сорилттой холбоотойгоор Хавсралт 17 ба холбогдох заавар материалд хамаарах нэмэлт өөрчлөлтийн санал, 2024 оныг "Хялбаршуулах жил" болгосонтой холбоотой хялбаршуулах чиглэлийн арга хэмжээний талаарх мэдээлэл, GAsEP-ийн 2 дахь хэвлэлийн танилцуулга;

б. GAsEP ба APAC дахь зорилтуудын хэрэгжилтийн байдал - Улс орнуудыг GAsEP-ийн гол тэргүүлэх чиглэлүүдийг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлж байгаа хүчин чармайлт/хийгдсэн ажлуудын талаар мэдээлэл хуваалцахын зэрэгцээ нисэхийн аюулгүй байдлын соёлын шилдэг туршлагыг хуваалцах зорилгоор дараах сэдвүүдийн хүрээнд танилцуулга, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Үүнд:

- Эрсдэлийн болон хариу арга хэмжээний талаарх мэдээллийг дээшлүүлэх;
 - AVSEC-д аюулгүй байдлын соёл болон боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх;
 - Технологийн нөөцийг сайжруулж, инновацыг дэмжих;
 - Хяналт ба чанарын удирдлагыг сайжруулах; болон
 - Бүс нутгийн хамтын ажиллагаа, дэмжлэгийг нэмэгдүүлэх
- в. Хэрэгжилт, чадавхыг бэхжүүлэх ба бүс нутгийн түншлэл - ICAO AVSEC-ийн хэрэгжилтийг дэмжих ба хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх (ISD-SEC), CASP-AP хөтөлбөрийн шинэчлэлт ба бүс нутгийн түншлэлийн зарим жишээнүүдийн талаарх мэдээлэл зэрэг болно.

Үр дүн:

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Удирдах Зөвлөлийн 19 дүгээр хурал (CASP-AP SCM/19) болон Ази, номхон далайн бүсийн Аюулгүй байдлын зохицуулалтын 12 дугаар форум нь (RASCF-APAC/12) оролцсоноор дараах үр дүнтэй болсон.

1. CASP-AP хөтөлбөрийн 2024-2025 оны төлөвлөгөөнд Монгол Улсад "Албадлагын арга хэмжээ" олон улсын семинарыг зохион байгуулах эрхийг авч сургалтын (CBT) болон хяналтын (ORR) хоёр шинэ программ хангамжийг хүлээн авч суурилуулах, ашиглах сургалтыг авахаар тусгуулж батлуулсан болно. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын дээрх хоёр арга хэмжээг Монгол Улсад зохион байгуулснаар нисэхийн аюулгүй байдлын байцаагч нар болон үзлэгийн шалгагч, багшлагч боловсон хүчний мэдлэг чадавхыг хамгийн бага зардлаар дээшлүүлэх боломж бүрдсэн.
2. Ази, Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөтөлбөрийн Удирдах Зөвлөлийн 19 дүгээр хурал (CASP-AP SCM/19)-ийн болон Ази, номхон далайн бүсийн Аюулгүй байдлын зохицуулалтын 12 дугаар форум нь (RASCF-APAC/12) оролцсоноор бусад улсын хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тулгамдаж байгаа асуудлаар мэдээллийг авч, тэргүүлэх туршлагатай танилцсан.
3. Иргэний нисэхийн ерөнхий газраас олон улсын байгууллагууд, бусад гишүүн улсын нисэхийн аюулгүй байдлын чиглэлийн байгууллагуудтай

харилцах харилцааг дээшлүүлж, хамтын ажиллаг хөгжүүлэхэд чухал үр дүнтэй байсан.

ТАНИЛЦСАН:

НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН
АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  Ц.БАТ

ХЯНАСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ХЭЛТСИЙН ДАРГА  Г.БАТБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

НААХЗА-НЫ АЭРОДРОМ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ
ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ  Г.МӨНХБОЛД